

ЖАЙКА-ИЙН МОНГОЛ ДАХ ТӨЛӨӨГЧИЙН ГАЗРЫН ДЭД ДАРГА ЁШИМУРА ТОКУЖИ-ИЙН ХЭЛСЭН ҮГ

Өнөөдрийн хуралд Жайка Монгол дах төлөөлөгчийн газрын Танака дарга оролцох байсан боловч эрүүл мэндийн шалтгаанаар оролцож чадахгүй болсон тул Ёшимүра миний бие оролцож байна. Өнөөдөр төслийн ХЗХ-ны 2 дугаар хуралд оролцож байгаадаа баяртай байна. 1 жилийн өмнө ХЗХ-ны анхдугаар хурал онлайнаар зохион байгуулагдаж байсан, өнөөдөр Япон Монгол талын багш судлаачид, Монгол талын Яам болон холбогдох төсөл хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнууд танхимаар оролцож байгаад баяртай байна. Өнөөдрийн хурал Япон Монгол талаас нийт 60 гаруй оролцогчтой хуралдаж байгаа нь энэхүү төсөлд анхаарал ихээр хандуулж энэ хэмжээгээр хүлээлт өндөр байгаа гэж ойлголоо. Энэхүү төсөл нь Монгол оронд тохиолддог Адууны ям болон үхрийн сүрье өвчинтэй тэмцэх арга боловсруулах гэсэн нэртэй Зооноз өвчний чиглэлийн төсөл юм. Энэ төслийг, ковидын цар тахал гарахаас өмнө хэрэгжүүлэхээр шийдвэр гарсан. Ковидын цар тахлыг бид нүдээрээ харж, биеэрээ мэдэрч, хүн болон малын халдварт өвчний талаар яаралтай арга хэмжээ авах шаардлагатай гэсэн тодорхой ойлголттой болсон төдийгүй Монгол Улсын Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр тодорхой хувь нэмэр оруулах байх гэсэн хүлээлттэй байгаа. Жайка-ийн хувьд ДЭМ, АУ-ны (Global Health Initiatives) санаачлагаар олон оронд эрүүл мэндийн олон төсөл хэрэгжүүлж байна. Энэ нь өвчнийг эмчлэх, урьдчилан сэргийлэх, сонор сэрэмжийг дээшлүүлэх гэсэн 3 том зорилтын хүрээнд төсөл хөтөлбөрөө хэрэгжүүлдэг. Манай энэхүү төсөл нь сонор сэрэмжийг дээшлүүлэх гэсэн зорилтын хүрээнд хэрэгжиж байгаа. Өнгөрсөн хугацаанд ковидын цар тахлын байдал, Улс төрийн нөхцөл байдлын улмаас импортын бараа бүтээгдхүүний эргэлт удааширсантай холбоотой төслийн тоног төхөөрөмжийн нийлүүлэлт хоцорсон, мөн Япон Монгол талын судлаачдын хөдөлгөөн нэлээд хоригдсон хэдий ч жилийн өмнөх нөхцөл байдалтай харьцуулахад сайжирч, цаашид төлөвлөгөөний дагуу хэрэгжих байгаа гэж найдаж байна. Өнөөдрийн ХЗХ -ны хурлаараа бид бүхэн төслийн одоогийн хэрэгжилтын явц, цаашдын төлөвлөгөө, тулгамдсан асуудлуудын талаар идэвхтэй ярилцаж шийдвэрлэх байгаа гэж найдаж байна. Та бүхэнд, Хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье. Баярлалаа.